



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/20

Аргатай

Г Хязгаарлалтын дэглэмийг  
тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын нутаг дэвсгэрт гарсан бод малын гоц халдварт “Мялзан” өвчний голомтонд тогтоосон хорио цээрийн дэглэмийг бууруулан 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Малын гоц халдварт бод малын “Мялзан” өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшигаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг Сумын онцгой комиссын орлогч дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсийн хүн ам, тээврийн хэрэгсэл, малын хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиуулж ажиллахыг хэсгийн цагдаа (О.Өлзий-Орших), Багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд хийгдэх халдвартгүйтгэл, малын эрүүл мэндийн үзлэгийг чанартай зохион байгуулахыг Боржигон-Эрдэнэ ХХК-ний малын эмч (Ц.Даариймаа), Бор дарс ХХК-ний малын эмч (Ц.Дуйнхаржав), Энх-Эрдэнэт сүрэг ХХК-ний малын эмч (П.Энхбаатар), мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Ц.Батбилэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.ЗОЛЗАЯА



482301057

This PC/local disk(D)2023 он/ээс нь актууд/захирамж 2023